



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 37

Шарга

Эрүүл мэндийн зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Аймгийн ИТХ-ын 2014 оны 04 дүгээр сарын 22-ны 37 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиг үүрэг бүхий сумын " Эрүүл мэндийн зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд салбар хоорондын зохицуулалтыг хангаж, тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг сумын Засаг дарга бөгөөд Эрүүл мэндийн зөвлөлийн дарга /Д.Түмэнбаяр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.АЗБАЯР

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2015 оны 10 дугаар сарын 01-ний
27 дугаар тогтоолын Хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: Д.Түмэнбаяр /Засаг дарга/
- Орлогч дарга: Т.Мөнхбаяр/ЗДТГ-ын дарга/
- Нарийн бичгийн дарга: Ц.Булгаа /Сум дундын эмнэлэгийн ерөнхий эмч/
- Гишүүд:
- Г.Тунгалаг/ЕБС-ын захирал/
 - Л.Сэрсмаа/ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга/
 - Н.Дашдаваа/Соёлын төвийн эрхлэгч/
 - О.Гүнрэгжав/СӨБ-ын эрхлэгч/
 - Г.Одгэрэл/Байгаль орчны хяналтын улсын байцаагч/
 - Д.Мягмар/ "Галт дулаан" ОНӨААТҮГ-ын дарга/
 - Т.Чандмаа / Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга /
 - Т.Ганчулуун / "Эшт сүндэл хайрхан" ОНӨААТҮГ-ын дарга/
 - П.Отгонбат /Нийгмийн халамжийн мэргэжилтэн/
 - Ж.Сосорбарам /Эрүүл мэндийн нийгмийн ажилтан/
 - Ц.Оюунлхагва /Нийгмийн даатгалын байцаагч/
 - У.Оюунчимэг /ЕБС-ын нийгмийн ажилтан/